



УСНЫ ГАЗРЫН ДАРГА  
З.БАТБАЯР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/388  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Усны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, тодотголоор нэмэгдүүлээгүйгээс үйл ажиллагааны орлого 82.7 хувь буюу 671,169.1 мянган төгрөгөөр давж биелсэн;
- Тайлант хугацаанд 64 харилцагчид 92,309.9 мянган төгрөгийн борлуулалтын төлбөрийн баримт илүү, орлогын гүйлгээ хийгээгүй 48 харилцагчид 33,589.9 мянган төгрөгийн баримтыг үндэслэлгүйгээр төлбөрийн баримтын цахим системд шивж олгосон;
- Итали улсад зохион байгуулагдсан "Усны үнэ цэнэ хурал"-д оролцсон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2 албан хаагчид 16,423.9 мянган төгрөгийн зардал гаргасан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 22 дугаар зүйл 22.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.9, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.3, 17.3.1,

17.3.2, 17.5 дахь заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

“Эгийн голын усан цахилгаан станц” төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажил гүйцэтгүүлэхээр 1,519,975.4 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулан 820,000.0 мянган төгрөгийн урьдчилгааг шилжүүлсэн, судалгааны ажилд ашиглах багаж, тоног төхөөрөмж, програм хангамжийг 380,045.0 мянган төгрөгөөр худалдан авч хүлээлгэн өгөөгүй үндсэн хөрөнгөнд бүртгэж, 9,658.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсаныг залруулсан.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Усны нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрт 44 харилцагчид 9,266,742.0 мянган төгрөгийн төлбөр ногдуулснаас 8,656,518.4 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй, Усны нөөц ашигласны төлбөрийг 308 байгууллагад 119,814,399.2 мянган төгрөгийн ногдуулалт хийснээс 22,708,175.5 мянган төгрөг дутуу төвлөрсөн, 50 байгууллагатай гэрээ дүгнээгүй дараа оны ногдуулалт хийсэн нь холбогдох журмыг зөрчсөн, Ус бохирдуулсны төлбөрт 252 дүгнэлтээр 11,121,090.2 мянган төгрөгийн төлбөр тооцоолж, 9,124,633.2 мянган төгрөгийг чөлөөлж, 105 харилцагчийн 327,520.9 мянган төгрөгийн төлбөр төвлөрөөгүй байгаа зэрэг нийт 31,692,214.8 мянган төгрөгийн төлбөрийн биелэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. "Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35 хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах" гэж заасан боловч усны төлбөрийн орлогын 9.0 хувьтай тэнцэх хөрөнгийг усны нөөц бохирдож хомстохоос хамгаалах, усны орчныг нөхөн сэргээхэд зарцуулж байна.

### **Бусад асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгадагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ